



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Мандал Энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА/2025/021/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040

Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн

Захирал: Д.Ариунаа

Утас: 99088151

Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	13
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт.....	14
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНОХБАХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

№ _____
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мандал энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, 26 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сахилгын шийтгэл ногдуулсан 240.9 мянган төгрөгийн суутгал хийгээгүй,
- Нөхцөл, шаардлага, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон гэрээ байгуулалгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр сургалтын төлбөрт **7,769.5** мянган төгрөгийг шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан,
- Анхан шатны баримт болох холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажаагүй **163,177.4** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,

- Анхан шатны баримт болох холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажаагүй **163,177.4** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- Тохилог Хараа ОНӨААТҮГ-т 2023 онд шилжүүлсэн боловч байгууллагын бүртгэлээс хасуулаагүй гэдэг шалтгаанаар тус газрын эзэмшилд биетээр байхгүй SUZUKI авто машины татвар болон 3,392 м2 газрын төлбөрт тайлант онд 408.7 мянган төгрөг төлсөн,
- Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 30,901.2 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,

Асуудлыг онцолсон хэсэг

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь тайлант онд сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжигдсэн 80,875.0 мянган төгрөгийн цахилгаан үүсгүүрийг хүлээн авч бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны орлогыг 1,598,188.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,564,136.8 мянган төгрөгөөр тогтоож, 34,051.7 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 1,696,724.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,727,626.0 мянган төгрөгийн зардал гарган, 30,901.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд дулаан үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэх зайлшгүй шаардлага тулгарсан тул 10,880.7 мянган төгрөгөөр сүлжээний эргэлтийн 55 квт насосыг 90квт болгон өргөтгөсөн байна.

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		01 дүгээр сарын 01	12 дугаар сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	18,428,863.75	358,617.68
1.1.02	Дансны авлага	49,508,091.18	30,773,173.66
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,829,671.08	28,487,555.12
1.1.04	Бусад авлага	4,705,541.00	5,949,024.43
1.1.06	Бараа материал	219,161,174.03	244,032,910.41
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	671,723.51	8,174,199.36
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	294,305,064.55	317,775,480.66
1.2.01	Үндсэн хөрөнгө	879,137,101.54	890,906,855.89
1.2.02	Биет бус хөрөнгө	3,861,000.00	2,772,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	882,998,101.54	893,678,855.89
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,177,303,166.09	1,211,454,336.55
2.1.1.01	Дансны өглөг	102,130,860.98	84,597,822.42
2.1.1.02	Цалингийн өглөг	489,576.00	504,108.12
2.1.1.03	Татварын өр	48,498,575.69	24,594,536.81
2.1.1.04	НДШ - ийн өглөг	18,332,064.04	50,430,150.04
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	8,162,839.00	6,481,274.80
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	177,613,915.71	166,607,892.19
2.2	Өр төлбөрийн нийт дүн	177,613,915.71	166,607,892.19
2.3.02	- хувийн	250,535,268.80	250,535,268.80
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,632,360.38	2,632,360.38
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	903,851,934.74	984,726,934.74
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(157,330,313.54)	(193,048,119.56)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(30,901,168.02)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(157,330,313.54)	(162,146,951.54)
2.3.11	Эздийн өмчийн дүн	999,689,250.38	1,044,846,444.36
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,177,303,166.09	1,211,454,336.55

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,577,571,220.99	1,696,724,890.18
02	Борлуулалтын өртөг	1,357,092,081.98	1,567,347,241.79
03	Нийт ашиг(алдагдал)	220,479,139.01	129,377,648.39
08	Бусад орлого	0.00	8,903.58
08.1	Орлогын дүн	0.00	8,903.58
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	149,442,326.60	155,625,703.50
12.1	Зардлын дүн	149,442,326.60	155,625,703.50
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(49,452,413.28)	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	(4,057,566.89)	(4,325,624.00)
17.1	Олз, гарзын дүн	(53,509,980.17)	(4,325,624.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	17,526,832.24	(30,564,775.53)
19	Орлогын татварын зардал	1,752,683.22	336,392.49
20	Татварын дараах ашиг (алдагдал)	15,774,149.02	(30,901,168.02)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	15,774,149.02	(30,901,168.02)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	1,038,079,161.91	-173,104,462.56	1,118,142,328.53
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	15,774,149.02	15,774,149.02
3	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	-134,227,227.17	0.00	-134,227,227.17
4	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	250,535,268.80	0.00	903,851,934.74	-157,330,313.54	999,689,250.38
5	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-4,816,638.00	-4,816,638.00
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-30,901,168.02	-30,901,168.02
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	80,875,000.00	0.00	80,875,000.00
8	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	250,535,268.80	2,632,360.38	984,726,934.74	193,048,119.56	1,044,846,444.36

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,867,984,561.83	1,937,753,223.33
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,781,116,610.09	1,852,398,451.11
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	30,301.70
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	576,077.00	5,000,004.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	86,291,874.74	80,324,466.52
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,851,234,851.66	1,954,850,969.40
1.2.1	Ажиллагчдад төлсөн	406,163,543.81	478,249,226.40
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	114,460,183.88	96,851,250.28
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	167,145,820.00	667,049,463.90
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	174,734,255.04	208,647,194.89
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	709,080,598.26	185,241,039.84
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	113,243,107.58	192,829,269.41
1.2.9	Бусад мөнгөн зарлага	166,407,343.09	125,983,524.68
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	16,749,710.17	(17,097,746.07)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	81,500.00
2.1.8	Бусад	0.00	81,500.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,879,905.00	891,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,879,905.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	891,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,879,905.00	-972,500.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	14,869,805.17	(18,070,246.07)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,559,058.58	18,428,863.75
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,428,863.75	358,617.68

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Зардлын төрөл	2024 оны төлөвлөгөө		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Цалингийн зардал	594,486,000.0	513,499,449.8	80,986,550.16	86.4
2	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	3,000,000.0	18,174,100.0	-15,174,100.00	605.8
3	НДШ-ийн зардал	86,655,400.0	71,530,107.6	15,125,292.37	82.5
4	Түүхий эд материал	505,454,700.0	631,490,275.9	-126,035,575.91	124.9
5	Гэрэл цахилгаан	72,186,000.0	111,309,574.2	-39,123,574.15	154.2
6	Цэвэр ус худалдан авах зардал	71,635,700.0	76,483,410.0	-4,847,710.00	106.8
7	Шатах, тослох материал	32,708,600.0	36,639,666.7	-3,931,066.69	112.0
8	МБҮ /нэвтрэх хөлс/	2,965,000.0	2,965,000.0	0.00	100.0

	Тээврийн зардал	БАУ-1 анги /Зам ашиглалт/	14,460,000.0	14,960,000.0	-500,000.00	103.5
		УБТЗ өртөө /таталт тавилтын хөлс/	10,525,500.0	11,025,500.0	-500,000.00	104.8
		Нүүрс буулгалтын зардал	7,200,000.0	7,200,000.0	0.00	100.0
9		Шуудан холбоо	3,070,000.0	3,331,560.9	-261,560.89	108.5
10		Албан томилолт	450,000.0	746,100.0	-296,100.00	165.8
11		Бичиг хэргийн зардал	1,928,500.0	2,245,492.3	-316,992.32	116.4
12		Сэлбэгийн зардал	11,580,000.0	5,014,090.9	6,565,909.08	43.3
13		Төлбөр хураамжийн зардал	109,200.0	154,200.0	-45,000.00	141.2
14		Усны шинжилгээний зардал	310,000.0	504,000.0	-194,000.00	162.6
15		ҮХ-ийн элэгдлийн зардал	61,569,600.0	82,074,972.9	-20,505,372.93	133.3
16		Аудит, Тусгай зөвшөөрлийн төлбөр	5,440,900.0	15,502,014.9	-10,061,114.85	284.9
17		Татвар, даатгалын зардал	436,900.0	1,068,836.0	-631,936.00	244.6
18		Нэг удаагийн тэтгэмж шагнал	34,985,000.0	51,079,079.9	-16,094,079.85	146.0
19		БҮТЭЗ	2,192,500.0	9,361,912.8	-7,169,412.78	427.0
20		Жижиг эд хогшил-багаж хэрэгсэл	1,450,000.0	6,115,204.2	-4,665,204.19	421.7
21		Хангамжийн материал, засвар	3,150,500.0	12,829,250.2	-9,678,750.18	407.2
22		ХАБЭА-н зардал	9,804,500.0	12,787,488.8	-2,982,988.82	130.4
23		Цэвэрлэгээ ариутгалын зардал	3,046,900.0	2,853,272.8	193,627.24	93.6
24		Хог хаягдлын зардал	1,020,000.0	850,000.0	170,000.00	83.3
25		Их засвар	5,723,000.0	8,479,000.0	-2,756,000.00	148.2
26		Ус бэлтгэх төхөөрөмжийн ашиг/зардал	5,692,400.0	1,691,900.0	4,000,500.00	29.7
27		Ажилчдын нийгэм хангамжийн	1,000,000.0	800,000.0	200,000.00	80.0
28		Сургалт, спорт арга хэмжээний зардал	7,900,000.0	13,669,897.4	-5,769,897.44	173.0
29		Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2,000,000.0	1,007,000.0	993,000.00	50.4
30		Авто худгийн дулааны зардал	0.00	183,700.0	-183,700.00	-
БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ			1,564,136,800.0	1,727,626,058.15	-163,489,258.15	-
1		Дулааны борлуулалтын орлого	1,437,672,400.0	1,487,343,872.6	(49,671,472.55)	103.5
		Дулааны хэсгийн бусад орлого	16,060,200.0	14,695,573.3	1,364,626.73	91.5
		Нүүрс борлуулалт	11,912,700.0	10,364,363.7	1,548,336.34	87.0
2		УХАТ- цэвэр ус борлуулалтын орлого	113,561,100.0	149,758,746.7	(36,197,646.72)	131.9

УТБ-ны усны борлуулалтын орлого	10,560,000.0	10,558,275.6	1,724.45	100.0
Засвар үйлчилгээний орлого	8,422,100.0	24,004,058.4	(15,581,958.43)	285.0
ОРЛОГЫН ДҮН	1,598,188,500.0	1,696,724,890.2	(98,536,390.18)	106.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Мандал энерго” ОНӨААТҮГ нь *“Мандал сумын төвийн хэсгийн хэрэглэгчдийг ажиллах амьдрах тав тухтай нөхцөлөөр хангаж ажиллах”* гэсэн зорилт тавин ажиллаж байна.

“Мандал энерго” ОНӨААТҮГ -ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх, түгээх
- Цэвэр ус дамжуулан борлуулах

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Мандал энерго” ОНӨААТҮГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАУХА тухай хууль зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Нийгмийн даатгалын ерөнхий хууль*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 08 дугаар сарын 30-нд нэмэлт өөрчлөлт орсон, гэх мэт.*

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Мандал энерго” ОНӨААТҮГ -ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Мандал энерго” ОНӨААТҮГ нь 2018 онд байгууллагын даргын тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд 2018 оноос хойш шинэчлэгдсэн холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцүүлж, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бодлогын баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Мандал энерго” ОНӨААТҮГ -ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,151.1 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,428.9	358.6	(18,070.3)
Авлага	56,043.3	65,209.8	9,166.5
Бараа материал	219,161.2	244,032.9	24,871.7
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	671.7	8,174.2	7,502.5
Үндсэн хөрөнгө	879,137.1	890,906.8	11,769.7
Биет бус хөрөнгө	3,861.0	2,772.0	(1,089.0)
Нийт хөрөнгө	1,177,303.2	1,211,454.3	34,151.1
Богино хугацаат өр төлбөр	177,613.9	166,607.8	(11,006.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	999,689.2	1,044,846.4	45,157.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,177,303.2	1,211,454.3	34,151.1

Дээрхи хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж төлсөн тооцоо, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 358.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,070.3 мянган төгрөгөөр буурсан нь зарцуулалттай холбоотойгоор,
- Авлага дансны үлдэгдэл 65,209.8 мянган төгрөг болж 9,166.5 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын илүү төлөлтөөс,
- Бараа материал дансны үлдэгдэл 244,032.9 мянган төгрөг болж 24,871.7 мянган төгрөгөөр өссөн нь аюулгүйн нөөц бүрдүүлэх ажиллагааг хангах зорилгоор 300 тонн буюу 24,871.7 мянган төгрөгийн нүүрсний нөөц үүсгэснээс,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 879,137.1 мянган төгрөг болж 11,769.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 11,880.7 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан ба сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжигдсэн 80,875.0 мянган төгрөгийн цахилгаан үүсгүүрийг үнэ төлбөргүй хүлээн авсан, 80,986.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас
- Өр төлбөр дансны үлдэгдэл 166,607.8 мянган төгрөг болж 11,006.1 мянган төгрөгөөр буурсан нь Шивээ овоо ХХК, Ширхэнцэг арвин хишиг ХХК-иудад төлөх өглөг буурснаас голлон шалтгаалсан байна.

3.5 Техник, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Мандал энерго” ОНӨААТҮГ -ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Мандал энерго” ОНӨААТҮГ -ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж, тайлант оны нийт орлогыг 1,598,188.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,564,136.8 мянган төгрөгөөр, 34,051.7 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 1,696,724.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,727,626.0 мянган төгрөгийн зардал гарган, 30,901.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,696,724.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 98,536.4 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар давж биелэсэн байна. Нийт зардлын гүйцэтгэл 1,727,626.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 163,489.2 мянган төгрөг буюу 10.4 хувиар хэтэрсэн нь элэгдлийн зардлыг зардлын төлөвлөгөөнд нэмж тусгаагүйгээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Мандал энерго” ОНӨААТҮГ -ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Мандал энерго” ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Ари файнэнс аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Эрдэнэмох, аудитор Б.Туяа нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал Д.Ариунаа, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Мандал энерго” ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг “Ари файнэнс аудит” ХХК-д 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01/19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,560,044.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 23,400.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Мандал Энерго” ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 26 төрлийн 170 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроож мэдээлсэн

- Санхүүгийн тайлан /бүтэн жил, хагас жилээр/
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт

Огт мэдээлээгүй мэдээлэл

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хавсралт файл-шийдвэрийн хуулбар
- Худалдан авах төлөвлөгөөний тайлан /бүтэн жилээр/-ийг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалт болон 6 дугаар зүйлийн 6.4.8, 6.10 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэннийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

“Мандал Энерго” ОНӨААТҮГ нь нүүрс болон шатахууны худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Нүүрс	505,454.7	505,454.7	НТШ
2	Шатахуун	32,708.6	32,708.6	Харьцуулалтын аргаар
	Нийт дүн	538,163.3	538,163.3	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах шатахуун худалдан авах сонгон шалгаруулалтад Шунхлай ХХК шалгаран гэрээ байгуулсан бол нүүрсний тендерийг 2 удаа зарласан боловч оролцогч ирээгүй тул Шивээ овоо ХК-тай нүүрс худалдан авах гэрээг байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад 34 арга хэмжээг түүвэрлэн шалгахаар төлөвлөн хэрэгжүүллээ. Аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааг авч санхүүгийн аудитын системд оруулсан бөгөөд ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	64,970.1	1	64,970.1	100
Зөвлөмж	3		3		100
Нийт дүн	4	64,970.1	4	64,970.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулга

Аудитаар нийт **72,823.7** мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Тайлант оны авлага дансны эхний үлдэгдэл 2023 оны аудитлагдсан тайлангийн эцсийн үлдэгдлээс 2,192.9 мянган төгрөгөөр дутуу, бусад авлага дансны эхний үлдэгдлийг 2,021.9 мянган төгрөгөөр дутуу, бараа материалын дансны эхний үлдэгдлийг 1,713.2 мянган төгрөгөөр илүү, татварын өр дансны эхний үлдэгдлийг 2,556.6 мянган төгрөгөөр дутуу, хуримтлагдсан үр дүнгийн дансны эхний үлдэгдлийг 55.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Смарт биллинг апплейкшнээр аж ахуйн нэгж, айл өрхийн цахилгаан, цэвэр усны сарын төлбөрийг үүсгэхэд 56,808.3 мянган төгрөгийн НӨАТ-ийн баримт давхар үүсгэсэн,
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт суутган тооцож авсан 10,902.1 мянган төгрөгийн татварыг авлагаар бүртгээгүй,

Аудитаар нийт **318,060.7** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **8,010.4** мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 163,586.1 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 146,464.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийн алдаанаас шалтгаалан тус газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн Б/68 дугаар тушаалаар засварчин Д.Алтанзулд үндсэн цалинг 20 хувиар бууруулах 1 сарын сахилгын шийтгэл ногдуулсан боловч **240.9** мянган төгрөгийн суутгалыг хийгээгүй байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлийг нөхөн суутгах төлбөрийн акт тогтоох.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

2. Байгууллагын төсөвт тусгагдсан гэх үндэслэлээр нөхцөл, шаардлага, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон гэрээ байгуулалгүйгээр буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр тус газрын дарга Д.Хадбаатарын ШУТИС-ийн сургалтын төлбөр **7,769.5** мянган төгрөгийг шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Хөдөлмөрийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь “*Хөдөлмөрийн гэрээнд, эсхүл ажил олгогчийн зардлаар суралцах дагалдах гэрээнд сургалтын хэлбэр, хугацаа, олговрын хэмжээ, суралцах хугацаанд ажилтны ажлын байрыг хадгалах, сургалтын дараа ажилтныг тухайн аж ахуйн нэгж, байгууллагад үргэлжлүүлэн ажиллуулах хугацаа, ажил олгогчийн гаргах зардлын хэмжээ, гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгана*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй буюу дагалдах гэрээгүйгээр олгосон сургалтын төлбөрийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд **163,177.4** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг анхан шатны баримт болох холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “*Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх*” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулсны үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Тохилог Хараа ОНӨААТҮГ-т 2023 онд шилжүүлсэн боловч байгууллагын бүртгэлээс хасуулаагүй гэдэг шалтгаанаар тус газрын эзэмшилд байхгүй SUZUKI авто машины татвар болон 3,392 м2 газрын төлбөрт тайлант онд 408.7 мянган төгрөгийг төлсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйл “*Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын эзэмшилд байхгүй дээрх хөрөнгүүдийг бүртгэлээс хасуулах албан шаардлага хүргүүлэх.

5.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Хуримтлагдсан ашиг, алдагдал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр **30,901.2** мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй бөгөөд үйл ажиллагаа явуулах тусам алдагдлын хэмжээ нэмэгдэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Тус газрын үйл ажиллагаанд санхүүгийн шинжилгээ хийж, өөрийгөө санхүүжүүлэн ажиллах.

2. Өглөгийн данстай холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт: МТА-ны "Байгууллагын татварын тодорхойлол"-д татварын өглөгийг **41,584.7** мянган төгрөгөөр дутуу, авлагыг **12,019.8** мянган төгрөгөөр илүү тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь” *Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж: Татварын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж , авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнах,

3.НӨАТ-ын орлоготой холбоотой

3.1 Илрүүлэлт: НӨАТ-ын тайлангаарх нийт орлогын дүнг Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын дүнгээс 56,859.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь” *Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах*” заалтыг зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: НӨАТ-ын тайланг үнэн зөв тайлагнах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.Шатахууны зарцуулалттай холбоотой

4.1 Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан 36,000.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог норм нормативаар тооцож бодоогүй, жолоочийн авсан дүнгээр зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь” *Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах*”, Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дүгээр тушаал “*100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Шатахууны 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтыг норм нормативаар нь тооцож, жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог бодож байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Тайлант оны авлага дансны эхний үлдэгдэл 2023 оны аудитласан тайлангийн эцсийн үлдэгдэлээс зөрүүтэй, хуримтлагдсан үр дүнгийн дансны эхний үлдэгдлийг дутуу бүртгэсэн.	1	5,113.3			1	5,113.3							
СӨХ-ийн программын смарт биллинг апплейкшнээр аж ахуйн нэгж, айл өрхийн цахилгаан, цэвэр усны сарын төлбөрийг үүсгэхэд НӨАТ давхар бүртгэсэн	1	56,808.3			1	56,808.3							
Татварын байгууллагаас тухайн байгууллагын дансыг хааж аж ахуйн нэгжийн орлогын албан татварт суутган тооцож авсан татварыг авлагаар бүртгээгүй.	1	10,902.1			1	10,902.1							
Дүн	3	72,823.7			3	72,823.7					3	72,823.7	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс			
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага
					Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дагалдах гэрээгүйгээр сургалтын төлбөр шилжүүлсэн	1	7,769.5	1	7,769.5											
Сахилгын шийтгэлийн суутгал хийгдээгүй	1	240.9	1	240.9											
Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй	1	163,177.4	1	163,177.4											
Шатахууны тооцоог бодолгүйгээр шатахуун олгосон	1	36,000.0					1	36,000.0							
Тус газрын эзэмшилд байхгүй хөрөнгийн татварыг төлсөн	1	408.7			1	408.7									
Өөрөө өөрийгөө санхүүжүүлж ажиллаж чадаагүй	1									1					
Татварын өглөг, авлагыг зөрүүтэй тусгасан	1	53,604.5					1	53,604.5							
НӨАТ-ын тайлангаарх нийт орлогын дүнг Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын дүнгээс илүү тайлагнасан,	1	56,859.7					1	56,859.7							
Дүн	8	318,060.7	2	8,010.4	2	163,586.1	4	146,464.2							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил						Төлбөрийн акт								
	Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2 мэдээгүй хугацаа хоцроон, 2 мэдээллийг огт мэдээлээгүй	1								1
Нийт дүн	1								1